Нийт зардлын 69.7 хувийг тэтгэврийн, 15.3 хувийг эрүүл мэндийн, 6.9 хувийг ҮОМШӨ-ний, 6.3 хувийг тэтгэмжийн, 1.8 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо 9 дүгээр сард 142.6 мянга, олгосон тэтгэврийн хэмжээ өссөн дүнгээр 392.9 тэрбум төгрөгт хүрчээ. Олгосон нийт тэтгэврийн 74.3 хувийг өндөр насны, 10.3 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.5 хувийг тэжээгчээ алдсаны, 11.9 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.

ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрийн яамны захиргааны статистик мэдээгээр дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо нийслэл хотод 2015 оны 9 дүгээр сарын эцэст 11159 болж, өмнөх оны мөн үеэс 19.8 хувь буюу 2755 хүнээр буурчээ. Нийт ажилгүйчүүдийн 6287 буюу 56.3 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг 24. Дүүргийн ажилгүйчүүд, УБ хотын дүнд эзлэх хувь



Насны бүлгээр авч үзвэл бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн 20.5 хувь буюу 2289 нь 15-24 насны, 39.6 хувь буюу 4416 нь 25-34 насны, 21.4 хувь буюу 2391 нь 35-44 насны, 18.5 хувь буюу 2063 нь 45-аас дээш насны хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 20.2 хувь буюу 2255 нь Чингэлтэй дүүрэгт, 17.6 хувь буюу 1967 нь Сүхбаатар, 15.9 хувь буюу 1772 нь Баянзүрх, 13.3 хувь буюу 1481 нь Сонгинохайрхан, 12.7 хувь буюу 1413 нь Хан-Уул, 8.2 хувь буюу 915 нь Баянгол, 7.2 хувь буюу 803 нь Налайх, 4.0 хувь буюу 446 нь Багануур, 0.9 хувь буюу 107 нь Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

2015 оны 9-р сард ажилгүй 3828 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 866 иргэн ажилд зуучлагдан орж, 2246 иргэн бүртгэлээс хасагджээ.

Хүснэгт 25. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр /10-р сарын 1-ний байдлаар/

	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2013 он	2014 он	2015 он	2013 он	2014 он	2015 он
Нийт ажилгүйчүүд	12892	13914	11159	100.0	100.0	100.0
Үүнээс: дээд боловсролтой	5136	5885	3967	39.8	42.3	35.6
Тусгай дунд боловсролтой	1104	964	764	8.6	6.9	6.8
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	756	685	573	5.9	4.9	5.1
Ерөнхий боловсролтой	5830	6319	5788	45.2	45.4	51.9
Мэргэжилгүй	66	61	67	0.5	0.5	0.6

2015 оны эхний 9 сард 33782 хүн дүүргийн хөдөлмөрийн хэлтэст ажилд орохоор шинээр бүртгүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 10.1 хувь буюу 3093 хүнээр өсчээ.
2015 оны эхний 9 сард 6743 хүн хөдөлмөрийн хэлтсээр зуучлуулан ажилд орсны 2.0 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт, 6.0 хувь нь төсөвт байгууллагад, 92.0 хувь нь компани, нөхөрлөл, хоршоо болон бусад газарт ажилд оржээ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2015 оны эхний 9 сард 31235 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 13 хүүхдээр олон байна.
Төрсөн нийт хүүхдийн 12.8 хувь буюу 3992 нь бусад аймгийн харъяат эхчүүдээс төрсөн байна.

Хүснэгт 26. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, эхний 9 сард

	2013 он	2014 он	2015 он	$\frac{2015}{2014}$%
Амаржсан эхийн тоо	29794	30951	31020	100.2
Амьд төрсөн хүүхэд	30007	31222	31235	100.0
Эхийн эндэгдэл	15	11	8	72.7
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	397	452	465	102.9
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	13.23	14.48	14.89	102.8

Нялхсын эндэгдлийн 26.3 хувь буюу 85 нь Сонгинохайрхан, 23.8 хувь буюу 77 нь Баянзүрх, 12.7 хувь буюу 41 нь Баянгол, 11.5 хувь буюу 37 нь Чингэлтэй, 10.8 хувь буюу 35 нь Хан-Уул, 9.9 хувь буюу 32 нь Сүхбаатар, 3.1 хувь буюу 10 нь Налайх, 1.6 хувь буюу 5 нь Багануур, 0.3 хувь буюу 1 нь Багахангай дүүрэгт тус тус гарсан байна.

Нялхсын эндэгдлийн 30.5 хувь буюу 142 нь бусад аймгийн харъяат байна. Өмнөх оны мөн үеэс нялхсын эндэгдэл 0.41 промилээр өсчээ.

Хүснэгт 27. Нийслэлд гарсан халдварт өвчин, эхний 9 сард

	хэмжих нэгж	2014 он	2015 он	өсөлт, бууралт	
				тоо/пункт	Хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн бүх хүн, үүнээс	бодит тоо	13451	33934	20483	2.5 дах
	10000 хүнд	107.87	262.90	155.03	
Вируст хепатит	бодит тоо	428	367	- 61	- 14.3
	10000 хүнд	3.43	2.84	- 0.59	
Менингит	бодит тоо	5	4	- 1	- 20.0
	10000 хүнд	0.04	0.03	- 0.01	
Цусан суулга	бодит тоо	1494	1754	260	17.4
	10000 хүнд	11.98	13.59	1.61	
Салхин цэцэг	бодит тоо	1693	2476	783	46.2
	10000 хүнд	13.58	19.18	5.6	
Гахай хавдар	бодит тоо	174	66	- 108	- 2.6 дах
	10000 хүнд	1.40	0.51	- 0.89	
Сальмонеллёз	бодит тоо	66	76	10	15.2
	10000 хүнд	0.53	0.59	0.06	
Улаан эсэргэнэ	бодит тоо	186	330	144	1.8 дах
	10000 хүнд	1.49	2.56	1.07	
Улаан бурхан	бодит тоо	-	18879	18879	-
	10000 хүнд	-	146.26	146.26	
Хоолны хордлого	бодит тоо	223	180	- 43	- 19.3
	10000 хүнд	1.79	1.39	- 0.4	
Ёлом	бодит тоо	75	74	- 1	- 1.3
	10000 хүнд	0.60	0.57	- 0.03	
Бруцеллёз	бодит тоо	10	14	4	40.0
	10000 хүнд	0.08	0.11	0.03	
Нярайн халдвар	бодит тоо	2	3	1	50.0
	10000 хүнд	0.02	0.02	-	
Гар хөл амны өвчин	бодит тоо	1314	959	- 355	- 27.0
	10000 хүнд	10.54	7.43	- 3.11	
Тэмбүү	бодит тоо	2667	3123	456	17.1
	10000 хүнд	21.39	24.20	2.81	
Заг хүйтэн	бодит тоо	1117	1536	419	37.5
	10000 хүнд	8.96	11.90	2.94	
Трихомониаз	бодит тоо	1275	1261	- 14	- 1.1
	10000 хүнд	10.22	9.77	- 0.45	
Шинээр илэрсэн сүрьеэ	бодит тоо	2082	2074	- 8	- 0.4
	10000 хүнд	16.70	16.07	- 0.63	
ДОХ	бодит тоо	27	10	- 17	- 2.7 дах
	10000 хүнд	0.22	0.08	- 0.14	

Нийслэлд 2015 оны эхний 9 сард 33934 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 2.5 дахин буюу 20483 хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 155.03 продицмилээр тус тус өсчээ.

Зураг 25. Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сараар

Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 55.6 хувийг улаан бурхан, 9.2 хувийг тэмбүү, 7.3 хувийг салхинцэцэг, 6.1 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 5.2 хувийг цусан суулга, 4.5 хувийг заг хүйтэн, 3.7 хувийг трихомониаз, 2.8 хувийг гар хөл амны өвчин, 1.1 хувийг вируст хепатит, 1.0 хувийг улаан эсэргэнэ, 0.5 хувийг хоолны хордлого өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.

НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2015 оны эхний 9 сард Нийслэлийн Тээврийн газраас Улаанбаатар хотын дотор болон хот орчимд 3.8 мянган км урттай, 121 чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулжээ.

Нийтийн тээврийн үйлчилгээнд хөлс төлөлтийг цахим системд шилжүүлж, хотын гудамж, замын хөдөлгөөний ачаалал, түгжрэлийг бууруулах, чиглэлүүдийн давхцлыг багасгах зорилгоор нийтийн тээврийн үйлчилгээний сүлжээний шинэчилсэн төлөвлөлтийг 2015 оны 8-р сарын 15-ны өдрөөс хэрэгжүүлж эхлээд байна.

Зураг 26. Зорчигч тээврийн чиглэлийн тоо

Зураг 27. Зорчигч тээврийн чиглэлийн урт

Дээрх ажлын хүрээнд их багтаамжийн автобусны үндсэн 73 чиглэлд 1010 тээврийн хэрэгсэл, түүний дотор угсраа 20 автобусыг үйлчилгээнд шинээр оруулан, 45 троллейбус, 989 их багтаамжийн автобус үйлчилж байна. Иргэдэд үйлчилгээ хүргэх шаардлагатай 5 цэгт (Хан-Уул дүүрэгт байрлах Ривер гарден хотхон, Маршал таун, Баянзүрх дүүргийн 21-р хороо, Ганц худаг, Сэлх, Баянгол дүүргийн 20-р хороо, 2 Хутагтын гудамж) шинэ чиглэлийн үйлчилгээг хүргэжээ.

Зураг 28. Нийтийн тээврийн үйлчилгээний шинэчилсэн сүлжээ



- Тойргоор явах хотын баруун тойргын 5 чиглэлд их багтаамжийн 82 автобус
- Тууш буюу хотын баруун зүүн хэсгийг шууд холбосон хэвтээ тэнхлэгийн авто зам дагуу үйлчлэх дамжин суултгүй явах 7 чиглэлд их багтаамжийн 171 автобус, троллейбус, багтаамж ихтэй 18 угсраа автобус
- Тууш буюу хотын хойд урд хэсгийг шууд холбосон босоо тэнхлэг дагуу үйлчлэх дамжин суултгүй явах 4 чиглэлд их багтаамжийн 68 автобус
- Богино эргэлтийн буюу хотын алслагдсан баруун хэсгийн иргэдийг 5 шар, Саппоро хүртэл, зүүн хэсгийн иргэдийг Офицеруудын ордон, Дүнжингарав худалдааны төв хүртэл богино эргэлтээр үйлчлэх 6 чиглэлд их багтаамжийн 54 автобус үйлчилж байна. Мөн хот орчмын буюу Шаргаморьт, Городок, Тэрэлж, Налайх, Өлзийт, Туул тосгон, Санзай, Найрамдал зуслан, Био комбинат, Эмээлт, Баруун түрүү зэрэг 13 чиглэлд их багтаамжийн 39 автобус, "бусад" буюу хуучин маршрутын дагуу үйлчлэх 34 чиглэлд их багтаамжийн 551 автобус тус тус үйлчилгээнд ажиллаж байна.

Улаанбаатар хотын хэмжээнд 2015 оны эхний 9 сард нийтийн тээврийн үйлчилгээг 57 аж ахуйн нэгж эрхэлсэн нь өмнөх оны мөн үеэс 9 аж ахуйн нэгжээр цөөрсөн байна. Тухайлбал, их багтаамжийн автобус бүхий хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн тоо 9.5 хувиар, бага, дунд багтаамжийн автобусаар үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжийн тоо 21.7 хувиар буурчээ. Гэсэн хэдий ч зорчигч тээврийн үйлчилгээний салбарт ажиллаж буй нийт аж ахуйн нэгжийн дийлэнх хэсгийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд эзэлсэн хэвээр байна.

Зураг 29. Зорчигч тээврийн үйлчилгээний салбарт ажиллаж буй ААН-ийн тоо



Нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүд 2015 оны эхний 9 сард 651.8 сая хүн километрийн ажил үйлчилгээг гүйцэтгэн, давхардсан тоогоор нийтдээ 191.7 сая хүн тээвэрлэж, 72.6 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс зорчигчийн тоо 9.4 хувиар буюу 19.9 мянган хүнээр, үйлчилгээний орлого 6.1 хувиар буюу 4.7 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Хүснэгт 28. Нийтийн тээврийн үйлчилгээ, төлбөрийн хэлбэрээр, 2015 оны эхний 9 сард

Тээврийн хэрэгсэл, төрөл, өмчлөлөөр	Аж ахуйн нэгж (тоо)	Орлого (тэрбум төгрөг)	Үүнээс:			Зорчигч (сая хүн)	Үүнээс:		
			карт	бэлэн мөнгө	нөхөн олго-вор		карт	бэлэн мөнгө	нөхөн олго-вор
Зорчигч тээврийн нэгтгэл (ОНӨААТҮГ)	1	23.1	0.8	12.4	9.9	62.2	2.5	35.0	24.7
Автобус (хувийн)	19	47.0	1.8	17.2	28.0	122.7	4.9	47.7	70.1
Троллейбус (хувийн)	1	0.42	0.02	0.16	0.24	1.2	0.06	0.55	0.6
Бага, дунд багтаамжийн автобус	18	2.1	-	2.0	0.1	5.6	-	5.4	0.15
Дүн	39	72.6	2.6	31.8	38.2	191.7	7.5	88.6	95.6

Төлбөрийн цахим хэлбэрт шилжиж байгаатай холбогдуулан Нийслэлийн Тээврийн газар нь УБ смарт ХХК-тай хамтарсан гэрээ байгуулан ажиллаж, троллейбус, их, дунд багтааамжийн нийт 1015 тээврийн хэрэгсэлд карт унших төхөөрөмжийг суурилуулан, картаар зорчих нөхцлийг ханган ажилласан байна. 2015 оны эхний 9 сард бүрдүүлсэн үйлчилгээний нийт орлогын 3.6 хувийг картын орлого, 43.7 хувийг бэлэн мөнгө, 52.7 хувийг "нөхөн олговор"-ын орлого эзэлж байна. 2015 оны 8-р сарын 15-наас хойш буюу шинэ үйлчилгээ нэвтэрч эхэлсэн хугацаанд дунджаар 460.0 мянган карт борлуулсан бөгөөд нийт зорчигчдын 50 орчим хувь нь картаар зорчиж байгаа ажээ.

Харин 2015 оны эхний 9 сарын байдлаар нийтийн тээврээр зорчигчдын 3.8 хувь нь картаар үйлчлүүлсэн байхад 46.3 хувь нь бэлэн мөнгө төлж, 49.9 хувь нь нөхөн олговрын хөнгөлөлтөөр зорчжээ. Өөрөөр хэлбэл, оны эхнээс нийтийн тээврийн хэрэгслээр давхардсан тоогоор 95.6 сая зорчигч үнэ төлбөргүй үйлчлүүлж, эдгээр хүмүүсийн үйлчилгээний төлбөрт төрөөс 38.3 тэрбум төгрөгийг нөхөн олговор хэлбэрээр тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд шилжүүлсэн байна.

Зураг 30. Зорчигчдын тоо, сая хүн, төлбөрийн хэлбэрээр



Зураг 31. Үйлчилгээний орлого, тэрбум төгрөг,төлбөрийн хэлбэрээр



Нийслэлийн Тээврийн газраас аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан "Нийтийн тээврийн үйлчилгээг эрхлэн гүйцэтгүүлэх тухай гэрээ"-гээр насанд хүрэгчид их, дунд багтаамжийн автобусаар 500 төгрөг, цахилгаан тээврээр 300 төгрөг, туслах болон

буухиа чиглэлийн бага багтаамжийн автобусаар 500-1300 төгрөг, хот орчмын чиглэлийн бүх төрлийн автобусаар 500-2300 төгрөгөөр (хүүхэд 200-1200 төгрөг) зорчиж байна. Мөн тус гэрээнд таксины үйлчилгээний нэг төлбөрт километрийн тарифыг 1000 төгрөгөөр тогтоож, үйлчилгээнд мөрдүүлэхээр заасан байна.

2015 оны эхний 9 сард нийтийн тээврийн парк шинэчлэлтээр их багтаамжийн 19 автобус, угсраа 20 автобус, дунд багтаамжийн 31 автобус үйлчилгээнд шинээр нэмэгдэж (хотоос алслагдсан хот орчмын Санзай, Найрамдал, Биокомбинат, Эмээлт, Мал бордох, Баруунтуруун, Жаргалант зэрэг чиглэлүүдэд үйлчилж эхэлсэн), стандартын шаардлага хангахгүй болж 12-оос дээш жилээр ашиглагдаж хуучирсан 255 тээврийн хэрэгсэл (их багтаамжийн хувийн 4 автобус, бага багтаамжийн 55 автобус, 14 троллейбус, 182 такси) үйлчилгээнээс хасагдсан байна.

Хүснэгт 29. Нийтийн тээврийн хөдлөх бүрэлдэхүүний тоо

Дансны хөдлөх бүрэлдэхүүн		2014 оны эхний 9 сар	2015 оны эхний 9 сар
Бүгд		2544	2161
Их багтаамжийн автобус	Төрийн өмч	252	300
	Хувийн өмч	867	894
Бага, дунд багтаамжийн автобус (хувийн)	Туслах чиглэл	273	147
	Буухиа чиглэл	359	190
Троллейбус	Төрийн	50	48
	Хувийн	15	8
Такси		728	574

2015 оны эхний 9 сард нийслэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ нь зориулалтын 2161 хөдлөх бүрэлдэхүүнтэй ажиллажээ. Эдгээрийн 15.6 хувь нь бага, дунд багтаамжийн автобус, 55.2 хувь нь их багтаамжийн автобус, 26.5 хувь нь такси байна.

2015 оны эхний 9 сард өдөрт дунджаар их, дунд багтаамжийн 957 автобус, 40 троллейбус, бага багтаамжийн 278 автобус, 575 такси нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллажээ. Шугаманд өдөрт ажилласан нийт тээврийн хэрэгслийн 47.3 хувийг хувийн хэвшлийн тээврийн хэрэгсэл эзэлж байв.

Зураг 32. Өдөрт ажилласан тээврийн хэрэгсэл, тоо

Зураг 33. Хүлээлтийн хугацаа, минут



Нийтийн тээврийн үйлчилгээний сүлжээг шинэчилсэн төлөвлөлтийн дагуу явуулах ажлын хүрээнд зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлүүдийн давхцлыг арилгах арга хэмжээ авагдаж, төрийн автобусны үндсэн чиглэлээс гадна дунд багтаамж, туслах болон зуслангийн чиглэлийн тоо багасч, эдгээр чиглэлүүдэд ажиллах тээврийн хэрэгслийн тоо өмнөх оны мөн үеэс 6.3-57.1 хувиар буурсан байна. Энэ нь зогсоолд ирэх автобус хоорондын зай буюу нийтийн тээврийн хүлээлтийн дундаж хугацаанд зохих нөлөө үзүүлж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад бага багтаамжийн автобусных 2 дахин нэмэгдэж, цахилгаан тээвэр, их багтаамжийн автобусных 1.1-1.4 хүртэл хувиар буурсан байна.

2015 оны эхний 9 сард нийслэлийн зорчигч тээврийн үйлчилгээний талаар иргэдээс дараах төрлийн нийт 1271 санал, гомдол Нийслэлийн Тээврийн газарт ирүүлсэний 93.2 хувийг нь шийдвэрлэж, барагдуулсан байна. Үүнд:

Зураг 34. НТ-ийн үйлчилгээний талаарх санал, гомдол, жил бүрийн эхний 9 сард

Зураг 35. Үйлчилгээний талаар ирүүлсэн санал, гомдлын барагдуулалт



МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО

Шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээний орлого 2015 оны эхний 9 сард 538.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 15.6 тэрбум төгрөгөөр буюу 3.0 хувиар өсчээ.
Нийт орлогын 76.3 хувь буюу 410.6 тэрбум төгрөгийг нийслэл хотын хүн амд үзүүлсэн үйлчилгээнээс бүрдүүлсэн байна.

Хүснэгт 30. Холбооны салбарын үндсэн үзүүлэлт

	Хэмжих нэгж	2014 оны эхний 9 сар	2015 оны эхний 9 сар
Нийт орлого	сая төг	сая төг	522883.6
Үүнээс: хүн амаас	сая төг	сая төг	384325.7
Суурин телефон цэг	тоо	тоо	179629
Үүнээс: айл өрхийн	тоо	тоо	153317
Утасгүй телефон	тоо	тоо	890
Үүрэн телефон хэрэглэгч	мянган хүн	мянган хүн	1895.5
КаТВ-ийн хэрэглэгч	тоо	тоо	277885

2015 оны эхний 9 сард нийслэлийн хэмжээнд суурин телефон цэгийн тоо 220.8 мянга болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22.9 хувиар нэмэгджээ.

Нийт суурин телефон цэгийн 187.1 мянга буюу 84.7 хувийг айл өрх ашиглаж байна. Өрхийн суурин телефон цэгийн тоо өмнөх оны мөн үеэс өссөн нь гурвалсан үйлчилгээний суурин утасны үйлчилгээг хэрэглэгч өрхийн тоо нийслэл хотод өсөн нэмэгдэж байгаатай холбоотой.

Зураг 36. Суурин телефон цэгийн тоо



Зураг 37. Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо

2015 оны эхний 9 сард Монгол Улсын хэмжээнд давхардсан тоогоор нийт 3.9 сая шахам хүн үүрэн телефон хэрэглэж байгаагийн 52.9 хувь буюу 2.0 сая гаруй хэрэглэгч нь нийслэл хотод байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үүрэн телефон хэрэглэгчийн тоо нийслэлд 163.8 мянгаар өссөн байна.

Үүрэн холбооны нийт хэрэглэгчдийн 333.4 мянга нь дараа төлбөрт үйлчилгээний, 1725.9 мянга нь урьдчилсан төлбөрт үйлчилгээний хэрэглэгчид байна. Хөдөлгөөнт утасгүй телефон буюу WLL үйлчилгээний хэрэглэгчдийн тоо 0.6 мянга орчим болж өмнөх оны мөн үеэс буурсан нь F-zone үйлчилгээний хэрэглэгчдийг CDMA болон GSM системд шилжүүлэх зохицуулалтын арга хэмжээ авч байгаагаас шалтгаалжээ. Нийслэлд 0.8 мянга гаруй хэрэглэгч сансарын холбоог эзэмшдэг байна.

Зураг 38. КаТВ, сувагт холбогдсон хэрэглэгчийн тоо



Кабелийн болон Ай Пи телевизийн 18 аж ахуйн нэгж байгууллага нийслэлийн 310.8 мянган хэрэглэгчдэд үйлчилж байна. Кабелийн сувагт холбогдсон нийт хэрэглэгчдийн 94.4 хувийг айл өрх эзэлдэг байна.

Кабелийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт аж ахуйн нэгжийн 16 нь нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж, хоногт дундажаар 50-130 гаруй сувгаар үйлчилгээ хүргэсэн байна. Нийслэлийн Налайх, Багануур дүүргийн хэрэглэгчдийн хувьд 49-63 хүртэл сувгаар кабелийн телевизийн үйлчилгээг хүлээн авч байна.

Гурвалсан үйлчилгээнээс бусад кабелийн телевизийн сувагт холбогдох шинэ тавилтын үнэ нийслэлийн төвийн 6 дүүргийн айл өрхөд 10.0-100.0 мянган төгрөгийн хооронд байхад үйлчилгээний төлбөрийн сарын хураамж өрхөд 4000-11000 төгрөгийн тарифтай байв.

АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж температур 2015 оны 9-р сард дунджаар 10.7^{0}С байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 0.8^{0}С-аар, олон жилийн дундажтай харьцуулбал 1.2^{0}С-аар тус тус дулаан байлаа. Энэ сард үнэмлэхүй их температур 27.3^{0}С, үнэмлэхүй бага температур -2.6^{0}С, хур тунадасны нийлбэр 22.6 мм, салхины үнэмлэхүй их хурд 18 м/секунд хүрчээ.

Хүснэгт 31. Агаарын бохирдолт, мг/м^3, 9-р сард

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдол /тоо/	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO_2	0.020	263	0.035	8	0.006
Азотын давхар исэл	NO_2	0.040	257	0.073	62	0.026
Тоосжилт	PM_{10}	0.100	300	0.312	84	0.081
	$PM_{2.5}$	0.050	166	0.076	7	0.027
Нүүрстөрөгчийн дутуу исэл	CO	10.000	725	2.000	-	0.436
Озон	O_3	0.100	584	0.084	-	0.035

Мэдээллийн эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар

Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2015 оны 9-р сард Улаанбаатар хотын Баруун дөрвөн зам болон 13-р хороолол орчимд тус бүр 30 удаа, Офицеруудын ордон орчимд 2 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж Телевиз орчимд 8 удаа, 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Толгой болон Телевиз орчимд тус бүр 13 удаа, Хархорин орчимд 12 удаа, Нисэх болон 32-ын тойрог орчимд тус бүр

11 удаа, Амгалан орчимд тус бүр 10 удаа, 1-р хороолол орчимд 7 удаа, Баруун 4 зам орчимд 6 удаа, Ургах наран хороолол 1 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Толгойт орчимд 3 удаа, Телевиз орчимд 2 удаа, 13-р хороолол болон Баруун 4 зам орчимд тус бүр 1 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.

Зураг 39. Хүхэрлэг хийн агууламж, мг/м^3



Зураг 40. Азотын давхар ислийн агууламж, мг/м^3



Зураг 41. Тоосны /PM$_{10}$/ агууламж, мг/м^3



Зураг 42. Нүүрстөрөгчийн дутуу исэл, мг/м^3



Туул голын усны найрлага Туул-Зайсан харуул цэгийн орчимд бохирдуулагч бодисын хэмжээ хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд хүчилтөрөгчийн хэмжээ хэвийн, амоны азот 6.9 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 4.5 дахин, нитридийн нэгдэл 3.9 дахин, эрдэс фосфор 1.5 дахин хүлцэх хэм хэмжээнээс хэтэрч Туул голын ус маш бохирдолтой хэвээр байна.

Хүснэгт 32. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м^3, 9-р сард

	Стандарт хэмжээ	"Туул-Зайсан" харуул цэг		"Туул-Сонгино доод" харуул цэг	
		Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч (O_2)	≥6	9.61	хэвийн	6.82	хэвийн
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ$_5$)	≤ 3	1.9		13.6	4.5 дахин
Нитридийн нэгдэл (NO_2)	≤ 0.02	0.001		0.078	3.9 дахин
Амоны азот (NH_4)	≤0.5	0.08		3.45	6.9 дахин
Эрдэс фосфор (P)	≤0.1	0.001		0.152	1.5 дахин

Мэдээллийн эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори

Хүснэгт 33. Агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м^3, 9-р сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл-Экспо төв	Баруун дөрвөн зам	1-р хороолол	13-р хороолол	32-ын тойрог	Офицеруу-дын ордон	Хархорин зах	Ургах наран хороолол	Нисэх	Толгойт	Телевиз	Амгалан
Хүхэрлэг хий SO_2	Дундаж	-	0.007	0.004	0.005	0.004	0.001	0.004	0.003	0.005	0.008	0.015	-
	Хамгийн их	-	0.016	0.020	0.014	0.010	0.007	0.011	0.010	0.010	0.014	0.035	-
	ХХХ*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	28	-
	Хэмжилтийн тоо	-	25	23	30	30	25	30	14	28	29	29	-
Азотын давхар Исэл NO_2	Дундаж	-	0.053	0.014	0.057	0.024	0.018	-	0.016	0.013	0.016	0.022	0.022
	Хамгийн их	-	0.066	0.034	0.073	0.034	0.062	-	0.029	0.022	0.029	0.027	0.033
	ХХХ*-с давсан хувь	-	100.0	-	100.0	-	9.0	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	30	22	30	30	23	-	16	28	29	29	20
Нүүрс-төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	-	0.755	-	0.413	0.467	-	0.382	0.206	0.314	0.421	0.612	0.357
	Хамгийн их	-	1.400	-	1.050	1.575	-	0.738	1.238	0.701	1.802	2.000	0.854
	ХХХ*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	89	-	89	90	-	90	48	84	87	87	61
Тоос PM_{10}	Дундаж	0.053	0.079	0.066	0.049	0.093	-	0.081	0.044	0.094	0.117	0.114	0.101
	Хамгийн их	0.099	0.163	0.131	0.096	0.170	-	0.179	0.138	0.258	0.312	0.261	0.193
	ХХХ*-с давсан хувь	-	20.0	23.0	-	37.0	-	40.0	7.0	39.0	45.0	45.0	50.0
	Хэмжилтийн тоо	30	30	30	30	30	-	30	14	28	29	29	20
Тоос $PM_{2.5}$	Дундаж	-	0.029	-	0.024	-	-	-	-	0.023	0.031	0.030	0.026
	Хамгийн их	-	0.076	-	0.073	-	-	-	-	0.045	0.063	0.057	0.042
	ХХХ*-с давсан хувь	-	3	-	3.0	-	-	-	-	-	10.0	7.0	-
	Хэмжилтийн тоо	-	30	-	30	-	-	-	-	28	29	29	20
Озон O3**	Дундаж	0.030	-	-	0.032	0.028	-	-	0.042	0.024	0.047	0.038	0.040
	Хамгийн их	0.084	-	-	0.061	0.057	-	-	0.070	0.061	0.081	0.069	0.066
	ХХХ*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	88	-	-	38	90	-	-	49	84	87	87	61

** Хүлцэх хэм хэмжээ, ** CO, O3 -ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон*

Байгаль орчны зөрчил Нийслэлд 2015 оны эхний 9 сард байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 454 зөрчлийг илрүүлжээ. Илрүүлсэн нийт зөрчлийн 29.7 хувийг геодези зураг зүй, кадастрын зөрчил, 28.5 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 19.8 хувийг газрын зөрчил, 6.8 хувийг ойн зөрчил, 4.2 хувийг газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчил, 3.1 хувийг ангийн зөрчил, 2.7 хувийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, 2.6 хувийг ургамал, хөрсний бохирдлын зөрчил, 2.4 хувийг ургамал, хөрсний бохирлын зөрчил, 0.2 хувийг усны зөрчлүүд эзэлж байна.

Илрүүлсэн нийт зөрчилд 82.9 сая төгрөгийн торгууль ногдуулж, ойн зөрчлөөс 1.9 сая төгрөг, ангийн зөрчлөөс 30.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр, ойн зөрчил гаргасан иргэдээс 14.1 сая төгрөгийн эд зүйлс хураан авчээ.

Хүснэгт 34. Байгаль орчны зөрчил, төрлөөр

Илрүүлсэн зөрчил, төрлөөр	2014 оны эхний 9 сард			2015 оны эхний 9 сард		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /сая.төг/	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /сая.төг/
Ой	33	14	5808.0	17	31	9984.0
Ан, амьтан	4	2	-	7	14	1344.0
Газрын	81	36	14248.0	13	90	30296.0
Ус	3	1	3572.0	3	1	-
Ургамал, хөрсний бохирдол	13	6	-	6	11	768.0
Агаар, химийн хорт бодис	49	17	1536.0	25	129	3088.0
Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай	151	41	21212.0	16	19	9992.0
Геодези зураг зүй, кадастр	28	18	1000.0	7	135	9707.0
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	1	2	9600.0	5	12	15360.0
Бусад	60	32	4350.0	15	12	2404.0
Бүгд	423	169	61326.0	114	454	82943.0

ХОТ ТОХИЖИЛТ

2015 оны эхний 9 сард нийслэл хотыг тохижуулах ажилд 31.4 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Тохижилтын ажлаар 30 объект тохижуулснаас 3 объектыг иж бүрэн тохижуулж, 27 объектод бичил тохижилт хийжээ.

Хотын нийтийн эзэмшилд шинээр 36.1 км урт явган хүний зам, шинээр 21 хүүхдийн тоглоомын талбайг байгуулсан байна. Нийтийн эзэмшлийн зам талбайд 114 ширхэг хогийн сав, 91 сандал, 31 сүүдрэвч, 13 усан оргилуур, 8044 метр хайс хамгаалалт шинээр, 3668.7 метр урт хайс хамгаалалт, 35 хогийн сав, 93 сандал, 17 усалгааны систем засварлаж 3.2 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

Нийтийн эзэмшлийн гудамж талбайд 1.9 км, орон сууцны хорооолд 37.2 км, гэр хороолол орчимд 219.2 км урт гэрэлтүүлэг хийж 2.6 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд гэрэлтүүлгийн асалт дунджаар 94.4 хувь, хот нийтийн реклам асалт 93.0 хувьтай байлаа.

Хүснэгт 35. Цэцэрлэгжилтийн зарим үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Бүгд	Хотын нийтийн эзэмшилд	Орон сууцны хорооолд	Албан газрын орчинд	Парк цэцэрлэгт
Нэг наст ургамал	мян.ш	35.0	23.9	4.3	6.7	0.1
Цэцэрлэгжүүлсэн талбай	мян.м^2	10.6	2.5	7.8	0.3	-
Зүлэгжүүлсэн талбай	мян.м^2	209.5	182.6	19.6	6.5	0.8
Цэцгийн мандал	мян.м^2	7.9	5.7	1.0	1.0	0.2
Шинээр тарьсан мод	мян.ш	120.3	43.2	9.5	51.5	16.1
Шинээр тарьсан сөөг	мян.ш	201.8	176.9	9.9	8.0	7.0

Тохижилтын ажлаар 34903 ширхэг нэг наст ургамал, 10.6 мянган м^2 талбайд цэцэрлэгжүүлэлт, 209.5 мянган м^2 талбайд зүлэгжүүлэлт, 7.9 мянган м^2 талбайд цэцгийн мандал шинээр байгуулж, үүнд 2.0 тэрбум төгрөгийг зарцуулав. Мөн 17.4 мянган м^2 талбайд нөхөн цэцэрлэгжүүлэлт, 92.8 мянган м^2 талбайд нөхөн зүлэгжүүлэлт хийж, 534.1 мянган м^2 зүлэгжсэн талбайг арчилж тордон 919.5 сая төгрөгийг зарцуулсан байна.
Нийтийн эзэмшлийн талбайд шинээр 120282 ширхэг мод, 201857 ширхэг сөөг тарьж, 56170 ширхэг мод, 51152 ширхэг сөөгийг арчилж тордон 0.7 тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэжээ.
Хог цэвэрлэгээний ажлаар 24020.8 мянган м^2 зам талбайг цэвэрлэж, 501.4 мянган тонн хог тээвэрлэж, Нарангийн энгэр, Морин даваа, Цагаан даваанд төвлөрсөн цэгт 683.2 мянган тонн хогийг дарж устгав. Дарж устгасан хогны 14.4 хувийг орон сууцны хорооллын, 35.6 хувийг гэр хорооллын, 40.6 хувийг аж ахуйн нэгж байгууллагын, 9.4 хувийг зам талбайн хог эзэлж байна.
Дүүргүүдийн тохижилт үйлчилгээний байгууллагууд 2015 оны эхний 9 сард 31160 золбин нохойг устгаж, энэ ажилд 220.6 сая төгрөг зарцуулав.

Хүснэгт 36. Тээвэрлэсэн хог, мян.тонн, дүүргээр

Дүүрэг, бусад байгууллагууд	Тээвэрлэсэн хог	Хог, бүтцээр					
		Орон сууц	Гэр хорооол	Албан байгууллага	Зам талбай	Хур хог	Бохир шингэн
Багануур	4.0	1.4	1.9	0.4	0.2	0.1	-
Багахангай	6.4	2.4	3.8	0.1	0.1	-	-
Баянгол	61.4	25.7	19.3	11.2	5.2	-	-
Баянзүрх	64.9	14.3	20.0	16.4	14.1	0.1	-
Налайх	58.8	11.0	38.1	4.7	2.6	2.4	-
Сонгинохайрхан	122.2	20.5	78.0	16.9	5.4	1.4	-
Сүхбаатар	53.1	14.0	17.1	17.3	1.6	1.8	1.3
Хан-Уул	40.0	8.1	11.4	17.8	2.6	0.1	-
Чингэлтэй	90.6	21.6	38.8	17.3	12.9	-	-
Дүн	501.4	119.0	228.4	102.1	44.7	5.9	1.3

ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Нийслэлийн хүн амд 2015 оны эхний 9 сард 24.8 сая м^3, аж ахуйн нэгж, байгууллагад 8.4 сая м^3 цэвэр усыг борлуулжээ. Борлуулсан усны нийт хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 37. Ус суваг ашиглалтын үйлчилгээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014 он IX сар	2015 он IX сар	$\frac{2015}{2014}$%
Шахсан ус	мян.м^3	40399.0	39130.6	96.9
Борлуулсан ус	мян.м^3	33755.7	33184.8	98.3
Хүн амд	мян.м^3	24402.0	24834.0	101.8
ААНБ-д	мян.м^3	9353.7	8350.8	89.3
Татан зайлуулсан бохир	мян.м^3	32889.8	32390.3	98.5
Хүн амаас	мян.м^3	22632.9	23026.7	101.7
ААНБ-аас	мян.м^3	10256.9	9363.6	91.3
Ус борлуулалтын орлого	сая төг	13815.2	19425.8	140.6
Хүн амаас	сая төг	7691.8	11417.3	148.4
ААНБ-аас	сая төг	6123.4	8008.5	130.8
Сувагжуулалтын орлого	сая төг	7849.8	11601.9	147.8
Хүн амаас	сая төг	3633.2	5133.9	141.3
ААНБ-аас	сая төг	4216.6	6468.0	153.4

Борлуулсан нийт усны 75.9 хувийг хүн амд борлуулсан ус, 24.1 хувийг аж ахуйн нэгж, байгууллагад борлуулсан ус эзэлж байна.

Хүн амд түгээсэн цэвэр усны 96.0 хувь буюу 23.8 сая.м^3 усыг төвлөрсөн шугамаар, 992.8 мян.м^3 усыг ус түгээх байраар, 9.6 мян.м^3 усыг тээвэрлэж түгээсэн байна.

Цэвэрлэх байгууламжаар 41.4 сая.м^3 бохирыг цэвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн 32.4 сая.м^3 бохир шингэнийг татан зайлуулсан байна.

Зураг 43. Борлуулсан ус, сараар, мян.м^3



Зураг 44. Татан зайлуулсан бохир, сараар, мян.м^3

ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Нийслэлийн нутаг дэвсгэрт 2015 оны эхний 9 сард нийт 374 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 11.3 хувиар өссөн байна. Нийт гамшиг осолд хүний үйл ажиллагаатай холбоотой осол 368, ус, цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл 4, гахайн мялзан өвчин 1, газар хөдлөлтийн тохиолдол 1 бүртгэгджээ. Хүний үйл ажиллагаатай холбоотой ослын тоонд сум галт хэрэгслийн осол 1, химийн бодисын осол 14, бичил уурхай, нурангины осол 2, усны осол 30, барилгын осол 7, үйлдвэрийн осол 2, бусад осол 312 бүртгэгдсэн байна. Гамшгаас нийт 214 хүнийг аварч, түүний уршгийг арилгах ажилд 3.8 сая төгрөг зарцуулжээ.

Хүснэгт 38. Гал түймрийн тоо, дүүргээр

Дүүрэг	2014 он	2015 он	2015 он / 2014 он
Бүгд	2036	2622	128.8
Багануур	27	40	148.1
Багахангай	5	9	180.0
Баянгол	318	350	110.1
Баянзүрх	478	636	133.1
Налайх	76	61	80.3
Сонгинохайрхан	388	570	146.9
Сүхбаатар	308	359	116.6
Хан-Уул	195	260	133.3
Чингэлтэй	241	337	139.8

Нийслэлд 2015 оны эхний 9 сард ой хээрийн 26 түймэр, ахуйн 2622 гал түймэр гарчээ. Ахуйн гал түймэр өмнөх оны мөн үеэс 28.8 хувиар нэмэгдсэн байна.

Гал түймрийн улмаас 26 хүн (үүнээс, хүүхэд 6) амь насаа алдаж, 23 хүн (үүнээс, хүүхэд 8) түлэгдэж гэмтжээ. Гал түймрийн аюулаас 385 хүн, 708 байшин барилга, 5.4 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг аварчээ.

Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилбал, цахилгаанаас 441, санамсаргүй байдлаас 1917, санаатай үйлдлээр 1, шалтгаан тогтоогдоогүй 179, бусад шалтгаанаар 84 гал түймэр гарсан байна.

Гал түймэрт 709 гэр, орон сууц, 347 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 108 машин техник, малын 88 хашаа, саравч, бусад төрлийн 1370 обьект өртсөн байна. Гал түймэрт иргэний хувийн өмчийн 1684, төрийн өмчийн 784, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 153, гадаадын хөрөнгө оруулалттай 1 обьект өртөж, нийт 11.9 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Зураг 45. Гал түймэр, шалтгаанаар



Зураг 46. Гал түймэр, байршлаар



Нийслэлийн Онцгой байдлын газраас 2015 оны эхний 9 сард 190 барилгын зураг төсөл, ашиглалтад хүлээн авч буй 421 барилгад хяналт тавьж ажиллажээ. Түүнчлэн 12000 айл өрх, 7879 обьектод үзлэг, шалгалт хийж, 35408 галын зөрчил илрүүлж, 148 байгууллагын үйл ажиллагааг нь зогсоож, байгууллага, албан тушаалтан, иргэнд заавал биелүүлэх 2037 албан шаардлага, 2422 мэдэгдэл хүргүүлж, 44.6 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

ГЭМТ ХЭРЭГ

2015 оны эхний 9 сард 13554 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9.8 хувь буюу 1214 хэргээр өсчээ.
Гэмт хэргийн илрүүлэлт 57.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.0 пунктээр дээгүүр байна.

Зураг 47. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Гэмт хэргийн улмаас 4933 хүн гэмтэж осолдож, 302 хүн нас барж, төр ард иргэдэд 64.7 тэрбум төгрөгийн хохирол учруулсны 26.4 хувь буюу 17.1 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 32.9 хувийг хулгайн, 25.9 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 9.6 хувийг залилан, 6.9 хувийг танхайн, 6.3 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюул-гүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг тус тус эзэлж байна.

2015 оны эхний 9 сард 41768 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 15.1 хувь буюу 7444 хүнээр буурсан байна.

Хүснэгт 39. Бүртгэсэн нийт гэмт хэрэг, төрлөөр, эхний 9 сард

	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2014 он	2015 он	Тоо	Хувь
Хүний амь	83	80	- 3	- 3.6
Хүчин	112	100	- 12	- 10.7
Дээрэм	445	324	- 121	- 27.2
Хулгай	3744	4458	714	19.1
Булаалт	145	146	1	0.7
Залилан	1021	1307	286	28.0
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	3523	3506	- 17	- 0.5
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	761	848	87	11.4
Бусдыг амиа хорлоход хүргэх	163	128	- 35	- 21.5
Ашиглах	123	125	2	1.6
Танхайрах	999	937	- 62	- 6.2
Бусад	1221	1595	374	30.6
БҮГД	12340	13554	1214	9.8

Хүснэгт 40. Бүртгэсэн нийт гэмт хэрэг, дүүргээр, эхний 9 сард

Дүүрэг	Нийт бүртгэсэн гэмт хэрэг		Гэмт хэргийн өсөлт, бууралт	
	2014 он	2015 он	Тоо	Хувь
Багануур	175	241	66	37.7
Багахангай	16	20	4	25.0
Баянгол	2005	2096	91	4.5
Баянзүрх	3020	3298	278	9.2
Налайх	253	335	82	32.4
Сонгинохайрхан	2251	2401	150	6.7
Сүхбаатар	1768	2360	592	33.5
Чингэлтэй	1752	1756	4	0.2
Хан-Уул	1100	1047	-53	-4.8
ДҮН	12340	13554	1214	9.8

Хүснэгт 41. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр, 2015 оны эхний 9 сард

Дүүрэг	Сэжигтэн тодорхойгүй хэргийн тоо	Үүнээс сэжигтнийг илрүүлж ял сонсгосон	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
Багануур	81	46	56.8
Багахангай	1	-	0.0
Баянгол	827	550	66.5
Баянзүрх	2026	1085	53.6
Налайх	95	66	69.5
Сонгинохайрхан	1499	855	57.0
Сүхбаатар	1450	832	57.4
Чингэлтэй	1164	679	58.3
Хан-Уул	435	278	63.9
ДҮН	7578	4391	57.9

Хүснэгт 42. Бүртгэсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр, эхний 9 сард

Дүүрэг	Нийт хулгайн гэмт хэргийн тоо		Үүнээс: хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо	
	2014 он	2015 он	2014 он	2015 он
Багануур	26	62	23	47
Багахангай	3	2	2	1
Баянгол	537	476	421	389
Баянзүрх	970	1190	818	1024
Налайх	50	78	39	67
Сонгинохайрхан	773	954	700	880
Сүхбаатар	551	890	418	685
Чингэлтэй	524	547	475	469
Хан-Уул	310	259	270	244
ДҮН	3744	4458	3166	3806

2015 оны эхний 9 сард онц хүнд хэрэг 250, хүнд хэрэг 802 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 8.1-14.6 хувиар буурч, харин хүндэвтэр хэрэг 6054, хөнгөн хэрэг 6448 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 12.3-12.4 хувиар өсчээ.

Зураг 48. Гэмт хэргийн тоо, ангиллаар



Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 10448 болж, 2014 оны мөн үеэс 10.0 хувь буюу 949 хүнээр өссөн байна.
Хэрэгт холбогдсон нийт сэжигтэн, яллагдагчийн 12.2 хувь буюу 1278 нь гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, 16.2 хувь буюу 1695 нь согтуугаар үйлдсэн, 5.2 хувь буюу 542 нь урьд ямар нэг ял шийтгэл хүлээж байсан хүмүүс үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 5.2 хувь буюу 541 нь хүүхэд, 18.0 хувь буюу 1881 нь эмэгтэйчүүд байна.